ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

# ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

9081005051, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,
Эрх чөлөөний талбайн баруун тал, MN tower 12 давхарт,
Утас: 77002033, 77002035, 77002037, Факс: 77002035,
Вэб:www.lgf.mn, И-мэйл:cgf@lgf.mn

2020.01.23 № 1/40

танай ______________ -ны № ______________ -т

"БИЗХАУЗ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД

Танай 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 05/20 албан тоотоор ирүүлсэн суудлын автомашин нийлүүлэх үнийн саналыг хүлээн авч сонгон шалгаруулалтад оролцуулав.

Танай ирүүлсэн Mitsubishi Delica-D5 автомашинийг 25.000.000 төгрөгөөр нийлүүлэх үнийн санал нь хамгийн бага үнийн болон техникийн тодорхойлолтыг бүрэн хангасан тендерээр шалгарсан тул автомашин нийлүүлэх гэрээ байгуулахыг үүгээр мэдэгдэе.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТБАЯР

УЛААНБААТАР ХОТ ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

000021

**БАТЛАВ.**

| **ЗАХИАЛАГЧ:** | **НИЙЛҮҮЛЭГЧ:** |
|---|---|
| ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН | "БИЗХАУЗ" ХХК |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БАТБАЯР | ЗАХИРАЛ А.ГАНХҮҮ |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

***[Зээлийн батлан даалтын санд автомашин нийлүүлэх]*** **гэрээ.**

Дугаар № 2020/001*[ЗБДС-Б-01]*

Улаанбаатар хот/аймаг

Нэг талаас ***[Зээлийн батлан даалтын сан]*** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас ***[Бизхауз ХХК]*** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 01 сарын 24-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь ***[Зээлийн батлан даалтын санд автомашин нийлүүлэх*** **гэрээ № 2020/001*[ЗБДС-Б-01]***-г автомашин (цаашид "бараа" гэх) ***[25000000 /хорин таван сая төгрөг]*** (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 25000000 төгрөгийн Сангийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь Бизхауз ХХК автомашин нэр төрлийн барааг 2020 оны 01 дүгээр сарын 23-наас 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд: Автомашины хувийн хэрэг, гаалийн бичиг баримт

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг[1];
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт

[1] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
|---|---|
| *[ЗАХИРГААНЫ ГАЗРЫН ДАРГА, Д.БАТЗОГСОХ]*<br>*[Гарын үсэг]*__________<br><br>ТАМГА<br><br>*[Чингэлтэй дүүрэг 5-р хороо, Тэнгис кино театрийн урд байрлах МН тауэр байрны 12 давхар]*<br>*[утас-77002035, факс -77002031]* | *[Захирал, А.Ганхүү]*<br>*[Гарын үсэг]*__________<br><br>ТАМГА<br><br>*[Регистр-6218849, Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, UBH центр 608 тоот]*<br>*[88118601, 99094423]*<br>*[ХААН банкны данс: 5431181592 ₮]* |